

МАНДАЛ ДААТГАЛ ХК-НИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх заалт, Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт болон 2026 оны 03 сарын 06-ний өдрийн Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Балдан овогтой Энхтүвшинг 2026 оны 03 сарын 06-ний өдрөөр тасалбар болгон, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Даваадорж овогтой Дөлгөөнийг 2026 оны 03 сарын 06-ний өдрөөс эхлэн Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсугай.
3. ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдох баримт материалыг Б.Энхтүвшингээс Д.Дөлгөөнд хүлээлгэн өгөх ажлыг протокол хөтлөн хүлээлцүүлэхийг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшинд үүрэг болгосугай.
4. Б.Энхтүвшинг нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас нь чөлөөлсөн тухай Санхүүгийн Зохицуулах Хороонд хууль тогтоомжийн дагуу мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Дөлгөөнд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ